

# Living the Lotus 8

*Buddhism in Everyday Life*

2025  
VOL. 239



## Хавай салбарын «Bon Dance» баяр, 2025.07.11-12



### Living the Lotus Vol. 239 (2025.08)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## “Магтах” нэн чухал

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Хүмүүжлийн үндэс

Миний уншиж судалдаг номонд гардаг сурган хүмүүжүүлэгч нарын дунд ижил үзэл баримтлалтай хоёр хүн бий. Тэд сурган хүмүүжүүлэх гэдэг нь зааж сургах бус “магтах” гэж үздэг. Тэдний нэг Моринобү Зоо багш бүр “Багш хүн зөвхөн магтаал сайшаалыг л хэлж ярих учиртай.” гэж хэлсэн.

Жишээлбэл хүүхдүүд сургуулийн гутлын тавиурт гутлаа хийхдээ хааш яаш зөрүүлж тавьсан байвал багш сурагчаа хараагүй байхад нь засаж янзалж тавих нь багшийн ажил ба хүүхдүүд яваандаа гутлаа зэрэгжүүлэн цэгцтэй тавьдаг болоод ирэхээр нь магтахад л болох аж. Сурган хүмүүжүүлэх, зааж сургах гэж үүнийг хэлнэ гэжээ.

Харин Хирасава Коо багш (Кёотоогийн их сургуулийн захирал асан) “Сурган хүмүүжүүлэх ухаан бол хүүхдийг яаж магтан сайшаахыг л судалдаг.” гэж хэлээд “Нэн чухал зүйл бол хүүхэд бүрийн онцлог чанарыг амилуулан хөгжүүлэх явдал бөгөөд баяр баясал, эрч хүч, хүсэл мөрөөдлийг өгөх чухал.” («Өнөөдөр ч гэсэн өөдрөг амьдаръя» Чичи хэвлэлийн газар) хэмээн магтан урамшуулахын утга учрыг тайлбарлажээ.

Би өнөөг хүртэл “хүн бэлдэх буюу хайрлан энэрэх сэтгэлтэй хүнийг өсгөн хүмүүжүүлэх”, “ирээдүйг бүтээх хүүхэд залуусыг уян зөөлөн сэтгэлтэй хүн болгох чухал” гэх мэт хүнийг өсгөн хүмүүжүүлэх ач холбогдлын талаар ярьж бичиж ирсэн. Яагаад гэвэл хүн бүрийн сэтгэл цэвэр тунгалаг байж гэмээнэ дэлхий ертөнц сайн сайхан оршиж, цаашлаад харилцан түшилцэж амьдардаг хамаг юмс зол жаргалтай болох учраас тэр. Харин сурган хүмүүжүүлэх мэргэжилтэн дээрх хоёр хүмүүн хүний хүмүүжлийн үндэс суурь нь “магтан сайшаах” гэсэн байгаа юм.

Хирасава багшийн “Танд өөрөө ч мэдэж таниагүй, сэтгэлийн тань хэд дахин гүнд нуугдсан гайхамшигт чанар бий. Тиймээс юу ч хийсэн ямагт өөртөө итгэлтэй бай.” хэмээх үг бас бий. Сурган хүмүүжүүлэх ухааны хувьд энэ бол магтаалын үг. Үүнийг бурхны сургаалаар аваад үзвэл хүнийг хүмүүжүүлэх гэдэг нь бурханлаг мөн чанараа олж нээхэд нь туслах явдал, харин магтах гэдэг нь хүний бурханлаг чанарт итгэх явдал юм байна гэж бодогдож байна.



## Итгэх ба хүндлэн мөргөх

Гэхдээ магтах гэдэг ятгүй эд. Бид магтах нь байтугай юм л бол загнаж зандарч, үглэж янших гээд байдаг шүү дээ. Ямарваа зүйл үр дүнгүй гэдгийг илэрхийлдэг «Хиганы дараах буудайн бордоо, хориос хойших эх эцгийн заавар» гэсэн зүйр үг шиг хүүхдийг загнаж сургах боломжтой нас бол үсрээд л гурван нас хүртэл байдаг ба түүнээс томроод ирэхээр, за бүр насанд хүрсний дараа бол хэчнээн загнаж зааварчиллаа гээд яс маханд нь шингэтэл ойлгуулахгүй л бол хүлээж авдаггүй.

Тэгвэл яавал дээр вэ? “Өөрөөрөө үлгэрлэж, учирлан ойлгуулж өөрөөр нь хийлгэж, магтан сайшаахгүй л бол хүн хөдөлдөггүй” (Ямамото Исорокү) гэх үг байдаг шиг загнахын оронд өөрөө эхлээд үлгэр дуурайл үзүүлж, түүнийг хийгээд сурчихаар нь магтаж урамшуулснаар хүний сэтгэл хөдөлдөг болов уу. Энэ үгийн төгсөлд “Хийж байгаад нь баярлаж талархан, итгэл хүлээлгэхгүй бол хүн хөгжихгүй” гэж бас бичсэн байдаг. Тэгэхээр бусдын бурханлаг чанарт бүрэн итгэж, хүндлэн мөргөх нь л хүний хүмүүжилд хамгийн чухал зүйл байгаа юм. Энэ үгэнд “Та бол хэрэгтэй хүн” гэсэн хайр энэрэл, итгэл найдвар шингэсэн байх ба ийнхүү үнэ цэнийг нь мэдрүүлж, амьдрах хүсэл тэмүүлэл, эрч хүч өгөх харилцаа нь давхар “би ч гэсэн ийм хүн болох юмсан” гэсэн хүслийг төрүүлдэг.

Нийгэмлэгийн тэргүүнээр ажиллаж байсан нэг хүн “Гишүүдийн ярианаас өөрөө юуг ойлгож, ямар ач буян олж эдэлснээ хэлэх нь тэр хүнд магтаал болдог.” гэж хэлж байж билээ. Өөрийн хийгээд бусдын бурханлаг чанарт бүрэн итгэж, хүндлэн мөргөж чаддаг цайлган цагаан сэтгэл байхгүй л бол бусдыг үнэн сэтгэлээсээ магтаж чадахгүй гэсэн чухал ойлголтыг эндээс сурч болохоор байна.

Бид өдөр тутамдаа ийнхүү зам мөрийг хэрэгжүүлэн хүмүүнийг өгсөн хүмүүжүүлж, өөрсдөө ч гэсэн хүний хувьд улам илүү өсөн дэвшихийг хүсэж залбирч явдаг болохоор Бурхан биднийг ч бас ямагт урамшуулж, магтан сайшаах нь дамжиггүй.

«Косей» сэтгүүл, 8-р сарын дугаараас



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Рисшо Косей Кай нийгэмлэгийн байгууламж

### Үүсгэн байгуулагчийн дурсгалын музей



#### Бяцхан мэдлэг

Дурсгалын музейд тусгай үзэсгэлэнгийн танхим байх ба жилд хэд хэдэн удаа шинэ үзэсгэлэн гардаг.

Энэ нь Үүсгэн байгуулагч, Мёокоо багш, Цагаан лянхуа судартай холбоотой янз бүрийн үзүүлэнгээр дамжуулан ямар нэг зүйлийг ойлгож анзаарах боломж болдог. Үзэсгэлэнгийн танхимд Хооринкакү цэцэрлэг талаас ордог.



Тус музей Үүсгэн байгуулагчтай уулзаж, түүнээс суралцаж, сургаал номыг нь түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор мэндэлснийх нь 100 жилийн ойгоор 2006 онд нээгдсэн. Музейн төв хэсэгт Үүсгэн байгуулагчийн төрсөн нутаг Сүганүмагийн дөрвөн улирлын өнгө төрхийг илэрхийлсэн "Бэлгэ тэмдэгт танхим" байрладаг. Энэхүү төв хэсгийн эргэн тойронд түүний амьдралын замналыг 5 үе шатад хуваасан үзүүлэн байдаг.

Мөн ажлын өрөөг нь бодитоор сэргээн үзүүлж, дотор нь "Үүсгэн байгуулагчтай уулзах булан" -г байгуулжээ.

Энэхүү музейд олон төрлийн түүхэн баримт, үзмэрүүдээр дамжуулан хүн бүр сэтгэл зүрхээрээ Үүсгэн байгуулагчтай уулзах боломжтой.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Байгууллагын зочид буудал



Байгууллагын зочид буудал бол Рисшо Косей кай удирдах төвд мөргөлөөр ирсэн гишүүдийн байрладаг газар юм. Олон зочныг нэгэн зэрэг хүлээн авах чадалтай, томоохон хэмжээний байгууламж болно.

Үүдний танхимыг Үүсгэн байгуулагчийн санаачлагаар бүтээсэн буддын шашны гурван ариун дээд уул болох Тас шувуун цогцолсон уул, Тяньтай уул, Хий уулын зургаар чимэглэж, Үүсгэн байгуулагчийн хүрэл хөшөөг байрлуулсан байдаг. Эдгээр шаазан ханын зурагт бурхны шашны утга учрыг тунгааж, хүн бүхэн Шагжамүни бурхны сэтгэл лүгээ адил сэтгэлтэй болоосой гэсэн Үүсгэн байгуулагчийн хүсэл шингэжээ.

### Бяцхан мэдлэг

Тас шувуун цогцолсон уул нь Энэтхэгт, Тяньтай уул нь Хятадад, Хий уул нь Японы Шига мужид байдаг. Тас шувуун цогцолсон уул бол Цагаан лянхуа судрыг анх номлосон газар гэдгээрээ алдартай. Тяньтай уул ч гэсэн Цагаан лянхуа судар Энэтхэгээс Японд уламжлагдан ирэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

## Цагаан лянхуа судрыг ойлгоно гэдэг нь

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу?

Японд зуны аагим халуун өдрүүд үргэлжилсээр байна. Манай орны зун жил бүр бүгчим чийглэг байдаг тул эрүүл мэндээ хадгалах нь амаргүй сорилт байдаг. Харин та бүхний маань бие лагшин тунгалаг уу?

Энэ сарын айлдварт Нивано ерөнхийлөгч Хирасава Коо багшийн сургаалаас “Сурган хүмүүжүүлэх ухаан бол хүүхдийг хэрхэн магтан сайшаах вэ гэдгийг л судалдаг. Нэн чухал зүйл бол хүүхэд бүрийн онцлог чанарыг амилуулан хөгжүүлэх явдал бөгөөд баяр баясал, эрч хүч, хүсэл мөрөөдлийг өгөх юм.” гэсэн үгийг эш татаад, “Магтах гэдэг нь бусдын бурханлаг чанарт итгэх явдал” гэж сургажээ.

Энэ үгийг унших зуур би Үүсгэн байгуулагчийн нэгэнтээ айлдсан “Аврах гэдэг нь тухайн хүнд амар амгалан, итгэл найдвар төрүүлэх явдал” гэсэн сургаалыг санасан юм. Хүн оюун санааны хувьд хөгжихийн тулд хүсэл тэмүүллийг бадраах нөхцөл буюу баяр баясал, урам зориг, амар амгалан, итгэл найдвар гэсэн сэтгэлийн тулгуур хүч зайлшгүй хэрэгтэй ажээ.

Үүсгэн байгуулагч амьд ахуйдаа “Амьдралын учрал тохиол бүрийг зөв хүлээгээд авчихдаг хүн болно гэдэг нь Цагаан лянхуа судрыг ойлгосны шинж юм шүү” гэж биднийг урамшуулж байсан. Яавал өдөр бүрийн учралыг “өрөвч энэрэнгүй хүнийг төлөвшүүлэх боломж” гэж хүлээн авч чадах вэ? Энэ сард ч гэсэн би үүнийг тунгааж, уулзаж учрах хүн бүрт сэтгэл зүрхээ зориулж, өдөр бүрийг чин сэтгэлээсээ бурхны үйлд шамдан өнгөрүүлэх болно.




Нью-Йорк нийгэмлэгийн Чикаго салбарын Мүраками Каё ахлагч (голын эгнээний дунд) түүний гэр бүл, найзууд Олон улсын хэлтэст зочлов. (зүүн захад Акагава хэлтсийн дарга)

# Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about  
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)